

COVID-19

-ийн сэжигтэй бол яах вэ?

Юуны түрүүнд зөвлөгөө авах хэрэгтэй!



Дэлгэрэнгүй мэдээллийг цахим хуудаснаас авна уу.
Та өөрийн мэддэг хэлээрээ мэдээлэл авах боломжтой.

COVID-19-ийн сэжигтэй үед...

● Эмнэлэг болон эрүүл мэндийн байгууллагад



очихоос өмнө лавлаж зөвлөгөө авна уу. Хот, дүүргийн лавлах газруудын мэдээллийг цахим хуудаснаас үзнэ үү.

● Зөвлөгөө авсны дараа тухайн нөхцөл байдлаас шалтгаалан арга хэмжээ авах болно.

● Та доорх нөхцөлийн аль нэгэнд хамаарагдаж байвал шууд холбоо барина уу.

● Амьсгал давчдах, ядарч сульдах, өндөр халуурах зэрэг шинж тэмдгийн аль нэг нь хүчтэй илэрч байвал.

● Хүндээр өвчлөх магадлал өндөртэй* хүнд бие халуурах, ханиалгах зэрэг харьцангуй хөнгөн ханиадны шинж тэмдэг илэрч байвал.

* Өндөр настан, чихрийн шижин, зүрхний дутагдал, амьсгалын эрхтний өвчин(Уушгины архаг бөглөрөлтөт өвчин гэх мэт) зэрэг архаг хууч өвчтэй хүмүүс, диализ эмчилгээнд орж байгаа хүмүүс, дархлаа дарангуйлагч эм бэлдмэл, хорт хавдрын эсрэг эм тариа гэх мэтийг хэрэглэдэг хүмүүс

● Дээр заасан нөхцөлөөс гадна бие халуурах, ханиалгах гэх мэт хөнгөн ханиадны шинж тэмдэг илэрч, үргэлжлээд байх үед (4 хоногоос илүү хугацаагаар үргэлжилж байвал заавал холбогдоно уу).

● Мөн жирэмсэн эхчүүд болон бага насны хүүхэдтэй эцэг эхчүүд эртхэн зөвлөгөө авна уу.

● Архаг хууч өвчтэй бөгөөд эрүүл мэндийн байдалд ямар нэгэн өөрчлөлт илэрсэн, эсвэл COVID-19-өөс бусад өвчний сэжигтэй бол юуны түрүүнд орхийн эмч рүү утсаар холбогдоно уу.



Амьсгал давчдах



Ядарч сульдах



Өндөр халуурах



Хүүхэд



Жирэмсэн эхчүүд

Эрүүл мэндийн байгууллагад үзүүлэхээр болбол...

● Эмчийн зөвлөгөөгүйгээр олон эмнэлэгт нэгэн зэрэг үзүүлэхээс татгалзана уу.

● Амны хаалт зүүж, гараа савандаж угаах, "ханиах үеийн дэглэм"-ийг анхааран баримтална уу.

* Ханиах, найтаах үедээ амны хаалт, салфетка, нусны алчуур юмуу эсвэл цамцны ханцуй, тохойгоороо ам, хамраа таглах.



Лавлах

● Хот, дүүргийн лавлах газруудын мэдээлэл гэх мэтийг цахим хуудаснаас үзнэ үү.

Цахим хуудсыг (Эрүүл Мэнд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны "COVID-19-ийн тухай олон хэл дээрх зөвлөгөө") эндээс үзнэ үү



<https://www.c19.mhlw.go.jp>

Дэлгэрэнгүй мэдээлэл, шинэ мэдээг цахим хуудаснаас үзнэ үү

Эрүүл Мэнд, Хөдөлмөр,
Нийгмийн Хамгааллын Яам



ひと、くらし、みらいのために
厚生労働省
Ministry of Health, Labour and Welfare